



МОНГОЛ УЛС  
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2024 оны 04 сарын 05 өдөр

Дугаар 4/151

Мөрөн сум

Сурагчдын амралтыг сунгах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Боловсролын ерөнхий хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.11, Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.5, 5.6 дахь заалт, аймгийн Онцгой комиссын 2024 оны 03 дугаар сарын 29-ны өдрийн 4 дүгээр хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хөвсгөл аймгийн хэмжээнд хаваржилт хүндэрч буй цаг үеийн нөхцөл байдалтай уялдуулан зарим сумын Засаг дарга, малчдаас ирүүлсэн хүсэлт, Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2024 оны 04 дүгээр сарын 02-ны өдрийн 1а/1273 дугаар албан бичгээр ирүүлсэн зөвшөөрлийн дагуу Мөрөн сумаас бусад сумдын ерөнхий боловсролын сургуулийн гуравдугаар улирлын амралтын хугацааг нэг долоо хоногоор сунгаж, дөрөвдүгээр улирлын хичээл сургалтын үйл ажиллагааг 2024 оны 04 дүгээр сарын 15-ны даваа гарагаас эхлүүлэх зохицуулалт хийсүгэй.

2.Дээрх зохицуулалттай холбогдуулан хичээл, сургалтын агуулгыг сурагчдад нөхөн эзэмшүүлэх үйл ажиллагааг хуулийн хүрээнд чанартай зохион байгуулж ажиллахыг Боловсрол, шинжлэх ухааны газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ш.Отгон-Эрдэнэд үүрэг болгосугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч М.Хуягбаатарт даалгасугай.

ДАРГА

П.ЛХАГВАЖАВ

